АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
2023 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТ
(Шинэжинст сум)

2023 оны 05 дугаар сарын 30 | Залаа

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Шалгуур үзүүлэлт | Хүрэх түвшин, үр дүн | Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг) | Хүрсэн түвшин, үр дүн | Хэрэгжилтийн хувь | Дээд шатны байгууллагын үнэлгээ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
| НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО | | | | | | | | | |
| 1 | 1.1. Эрүүл иргэн-Ирээдүйн үнэт зүйл | 1.1.12. Шинэжинст сумын Эрүүл мэндийн төвийн засвар | | Гүйцэтгэлийн хувь | 100 | | Эрүүл мэндийн төвийн барилгын их засварын ажил нь 437763837 төгрөгийн зураг төсөвтэй бөгөөд аймгийн Хөрөнгө оруулалтын сангаас 2023 онд 50 сая төгрөг, 2024 онд 50 сая төгрөгийн төсөв батлагдсан учир 2024 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийх ажил дээр дутагдаж байгаа 337763837 төгрөгийн ажлын санал авахаар сумын хөгжлийн бодлого төлөвлөлттэй холбогдсон саналын жагсаалт гаргаж санал авч байна. 2023 онд аймгийн Орон нутгийн өмчийн газар дээр тендер зарлагдаж байгаа болно. | 0% | 0% |
| 2 | 1.5. Халамжаас-Хөдөлмөрт | 1.5.1. Аймгийн бүтээн байгуулалтын ажилд ажил хайгч бүртгэлтэй иргэдийг хамруулан хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж ажлын байрыг нэмэгдүүлэх | | Ажлын байраар хангагдсан иргэдийн тоо | 1310 | | Хэрэгжээгүй. | 0% | 0% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | 1.7. Хонгорын иргэн-Хонгорын баялаг | 1.7.5. Алслагдсан сум, багийн малчдад зориулсан соёл хүмүүжлийн олон талт арга хэмжээ зохион байгуулах | | Арга хэмжээ зохион байгуулсан сумын тоо | 10 | | Сумын нийт ард иргэдийг хамарсан үйл ажиллагааг эхний хагас жилийн байдлаар хамтарсан болон сумын ардын авьяастнуудын тоглолтыг 6 удаа, нийтийн цэнгээнт бүжиг 10 удаа, нийтийг хамарсан хурал зөвлөгөөн болон бусад арга хэмжээ 15 удаа тус тус зохион байгууллаа. | 30% | 70% |
| ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО | | | | | | | | | |
| 4 | 2.3. Эрүүл хөрс-Эрүүл хүнс | 2.3.1. Сарлаг үхэр , баталгаажсан үйлдэр омгийн хээлтэгч малд шилэн сонголт хийх | | Шилэн сонголтод хамрагдсан малын тоо /мянга/ | 11 | | Тогтвортой ноолуур төслийн санхүүжилтээр цөм сүрэг бүхий 14 малчин өрхийн мал сүрэгт аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал аж ахуйн албаны дарга Тэгшбаяр, мал үржлийн албаны мэргэжилтэн, улсын байцаагч Э.Бумбаяр нарын бүрэлдэхүүнтэй комисс хянан баталгаа явуулж бүтээгдэхүүний дээж авч лабораторид шинжлүүлэхээр илгээлээ. Улсын төсвийн хөрөнгөөр цөм сүргийн хээлтүүлэгчийг бий болгон орон нутагт ашиглуулахаар зарласан тендерт шалгарсан аж ахуй нэгж, малын удмын сангийн мэргэжилтнүүд 5 дугаар сарын 23-нд орон нутагт ажиллаж малчдын сууриас шилэн сонголт хийж өсвөр хээлтүүлэгчийг сонгож бойжуулахаар гэрээ байгуулав. | 90% | 90% |
| 5 | | 2.3.3. Шаардлагатай сумдын бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлж худаг гаргах, засварлах | | Шинээр гаргах худгийн тоо, засварласан худгийн тоо | 7 1 | 21 сая төгрөг - Орон нутгийн хөгжлийн сан | Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор Орон нутгийн хөгжлийн төсөвт 21 сая төгрөгийг төсөвлөн уст цэгийн хайгуулын ажлыг "Гео дата процессинг" компаниар гэрээ байгуулан хийлгүүлж гүйцэтгүүллээ. Ажлын гүйцэтгэлийн тайланг хүлээн авлаа. | 70% | 70% |
| 6 | | 2.3.4. Үлийн цагаан оготны судалгаа хийж, устгалын | | Устгал хийгдсэн талбайн / | 8 | | Суманд хамааралгүй заалт | 0% | 0% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | ажил зохион байгуулах | | хэмжээ /мян.га | | | | | |
| ГУРАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО | | | | | | | | | |
| 7 | 3.1. Эх байгаль-Ногоон байгууламж | 3.1.2. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх | | Тарьсан модны тоо | 500000 | | Сумын хэмжээнд “Нэг сая мод тарихад танай өрхийн таван мод нэмэр” уриатайгаар хаврын мод тарилтын ажлыг өрхүүд рүү чиглэсэн үйл ажиллагаа зохион байгуулж байна. Нийт 35 өрх 260 ширхэг модыг хашаандаа суулгаж тарилаа. Сумын төвийн ойн зурвас байгуулсан газарт 1500 ширхэг модны суулгацыг тарихад Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газрын 25 албан хаагч хамрагдаж ажиллалаа. Эрүүл мэндийн төв ажилчдынхаа тоогоор 30 суулгацыг байгууллагын эзэмшил газарт тарьсан. Бусад модны талбайд тарих 829 суулгац бэлтгэгдсэн байгаа бөгөөд цаг уурын байдлаас түр хойшлогдоод байна. Сумын хэмжээнд нийт 1930 ширхэг мод тарихаар бэлтгэн 1760 суулгацыг тарьсан үзүүлэлттэй байна. | 30% | 50% |
| 8 | | 3.1.12. Эвент арга хэмжээ зохион байгуулж, оролцох | | Гадаад, дотоод жуулчдын тоо | 200<br>17000 | | Эвент арга хэмжээ 1 удаа зохион байгуулагдсан. Малчид, төлчдийн зөвлөгөөний үеэр тэмээний уралдаан, бөхийн барилдаан зохион байгуулагдаж нийт 320 гаруй иргэд хамрагдсан. Гадаадын 5 иргэн уг арга хэмжээг үзэж сонирхсон. | 30% | 90% |
| ДӨРӨВ. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО | | | | | | | | | |
| 9 | 4.1. Ээлтэй төлөвлөлт, эрсдэлгүй амьдрал | 4.1.14. Шинэжинст сумын зам засвар | | Гүйцэтгэлийн хувь | 100 | | Аймгийн Засаг даргын Тамгын газраас нэгдсэн журмаар тендер зарлахаар санхүүжилт хүлээгдэж байна. | 0% | 0% |
| 10 | | 4.1.35. Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн | | Нутаг дэвсгэрийн | 20 | "ENSURE" төслөөс төгрөг | Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг 2020 онд "Газар дэлхий" ХХК- | 100% | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | төлөвлөгөө боловсруулах | | төлөвлөгөө боловсруулсан сумын тоо | | | аар хийж гүйцэтгүүлэн төлөвлөгөөний дагуу ажиллаж байна. | | |
| ЗУРГАА. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО | | | | | | | | | |
| 11 | 6.1. Ухаалаг Засаглал | 6.1.1. Иргэдэд зориулсан "Хамтдаа шийдье" төсөлт арга хэмжээг хэрэгжүүлэх | | Хамрагдсан өрхийн тоо | 5000 | | Хүлээгдэж байгаа. | 0% | 0% |
| 12 | | 6.1.2.1. bayankhongor.igovernment.gov.mn сайтын нэмэлт хөгжүүлэлт | | Гэрээний хэрэгжилтийн хувь | 53400,80 | | Төрийн үйлчилгээний чанар, бүтээмжийг сайжруулах, цахим хэлбэрээр авах боломжтой үйлчилгээг ард иргэдэд сурталчлан таниулах, шинэчлэлтийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор Төрийн үйлчилгээний операторчийн ажлын байрыг орон нутгийн нөөц боломжид тулгуурлан тусгай орон тооны болгон баталж e-mongolia, shinejinst.bkh.gov.mn зэрэг сайтуудыг хариуцуулан ажиллуулж байна. Ард иргэдэд цахим мэдээллийн нэгдсэн системийн талаар сургалт орж давхардсан тоогоор 120 гаруй иргэн хамрагдсан байна. | 90% | 90% |
| 13 | | 6.1.3.1. "Эрүүл монгол хүн" үндэсний хөдөлгөөний хүрээнд хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх | | Хэрэгжилтийн хувь | 85 | | Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, аймгийн удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг сар бүр хугацаанд нь тайлагнан ажиллаж байна. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн хөгжлийн төлөвлөгөө, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, дэд | 70% | 70% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хөтөлбөрүүдийн 2023 оны хагас жилийн хэрэгжилтийг хугацаанд нь тайлагналаа. | | |
| 14 | 6.1. Ухаалаг Засаглал | 6.1.7. Гамшгаас хамгаалах “Иж бүрэн”, команд штаб, Засаг даргын нэрэмжит бэлэн байдлын үзлэг зохион байгуулах | | Зохион байгуулсан үзлэгийн тоо, Оролцооны хувь | 10, 80 | Орон нутгийн төсвөөс 5,0 сая төгрөг | Аймгийн Засаг даргын 2023 оны 4 сарын 10-ны “Гамшгаас хамгаалах дадлага, сургууль зохион байгуулах тухай” А/191 дүгээр захирамжаар томилогдсон Онцгой байдлын газрын орлогч, урьдчилан сэргийлэх тасгийн дарга, дэд хурандаа Б.Мягмарсүрэнгээр ахлуулсан ажлын хэсэг 4 сарын 18-20-ны өдрүүдэд Шинэжинст суманд ажиллаж төрийн болон нутгийн захиргааны байгууллага, аж ахуй нэгжийн гамшгийн үеийн харилцан ажиллагааг сайжруулах, алба, мэргэжлийн ангийн бэлтгэл, бэлэн байдлыг дээшлүүлэх зорилгоор гамшгаас хамгаалах “Иж бүрэн” дадлага, сургууль зохион байгууллаа. Сумын Онцгой комисс, штабын удирдлагын харилцан ажиллагааг сайжруулах, мэргэжлийн ангийн бэлтгэл, бэлэн байдлыг хангах, сум, аж ахуй нэгж байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөний тодотголыг хийж, заавар, зөвлөмж өгөх, объектын болон ой хээрийн түймэр, Зоонозын халдварт өвчин, газар хөдлөлтийн гамшгийн тухай, аймгийн хэмжээнд тохиолдож буй аюулт үзэгдэл, ослын тухай урьдчилан сэргийлэх арга хэмжээ, ослын үеийн удирдлагын системийн тухай ойлголт, штабын дадлага зохион байгуулах нь зэрэг сэдвүүдээр танхимын сургалт орсон. Мэргэжлийн ангийн нийт 100 орчим бүрэлдэхүүнийг “Яаралтай цуглар” дохиогоор ажиллуулан бэлтгэл, бэлэн байдлыг шалгаж, хүн нэг бүрийн бэлэн байдлын үүргэвчинд үзлэг | 100% | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хийж, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг жигдрүүлж үнэлгээ дүгнэлт өгөв. Сумын Засаг даргын 2023 оны А/29 дүгээр захирамжаар байгуулагдсан сайн дурын хэсгүүдийн бүрэлдэхүүнд объектын гал түймэр унтраах, аврах ажиллагааг зохион байгуулах багаж хэрэгслийг ажиллуулах талаар сурган зааварлаж, бэлтгэл, бэлэн байдлыг хангах, түймрийн голомтод хэрхэн ажиллах талаар дадлага, сургуулилт хийж арга зүйн зөвлөгөөгөөр хангалаа. Мөн сумын “Хүн эмнэлэг”-ийг зоонозын халдварт өвчин гарсан үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар дуурайлган үзүүлэх дадлага сургуулийг зохион байгуулж удирдлага, сайн дурын хэсгүүдийн мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэн ажиллалаа. | | |

ХЯНАСАН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Л.БАТХУЯГ

БИЕЛЭЛТ ГАРГАСАН
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН Г.БАТЧИМЭГ

# АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2023 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТОВЧОО

(Өөрийн үнэлгээ)

2023 оны 05 дугаар сарын 30 Залаа

| АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2023 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТОВЧОО | | | |
|---|---|---|---|
| Хэрэгжилт гаргах нийт арга хэмжээний тоо: 14 | | | |
| Үнээс | Үр дүнтэй | **100%** | **2** |
| | Тодорхой үр дүнд хүрсэн | **70-90%** | **4** |
| | Эрчимжүүлэх шаардлагатай | **30-50%** | **3** |
| | Үр дүнгүй | **0%** | **5** |
| | Хэрэгжих хугацаа болоогүй | **Х.Б** | - |
| | Аймаг, нийслэлийн хөгжлийн төлөвлөгөөний хагас жилийн хэрэгжилт **44%** хувьтай байна. | | |

oOo

# АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2023 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТОВЧОО

(Дээд шатны байгууллагын үнэлгээ)

2023 оны 05 дугаар сарын 30 Залаа

| АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2023 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТОВЧОО | | | |
|---|---|---|---|
| Хэрэгжилт гаргах нийт арга хэмжээний тоо: 14 | | | |
| Үүнээс | Үр дүнтэй | **100%** | **2** |
| | Тодорхой үр дүнд хүрсэн | **70-90%** | **6** |
| | Эрчимжүүлэх шаардлагатай | **30-50%** | **1** |
| | Үр дүнгүй | **0%** | **5** |
| | Хэрэгжих хугацаа болоогүй | **Х.Б** | - |
| | Аймаг, нийслэлийн хөгжлийн төлөвлөгөөний хагас жилийн хэрэгжилт **52%** хувьтай байна. | | |

oOo